



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 4 сарын 04 өдөр

Дугаар 125


Улаанбаатар хот

Даатгалын байгууллагад аудит хийх
эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор баталсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шонхор үнэлгээ аудит” ХХК-д даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Шонхор үнэлгээ аудит” ХХК /Б.Эрдэнэ-Очир/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН